



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 16

Номгон

Төрийн захиргааны зарим албан хаагчдад
зэрэг дэв олгох санал батлах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.8.2, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 06 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны албан хаагчдад төрийн алба хаасан болон тухайн албан тушаалд ажилласан хугацаа, төрийн албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох саналыг хавсралтаар баталсугай.

2.Төрийн захиргааны албан хаагчдад шинээр болон ахиулан олгох зэрэг дэвийн саналыг УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч (Д.Сарангарав)-д даалгасугай.

ДАРГА  Д.ЭНХЖАРГАЛ